

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/291/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/157  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 97,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

## Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	132,328,213.51	247,628,521.50
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	92,757,537.72	201,855,418.71
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	92,757,537.72	201,855,418.71
3121	Төгрөг	92,757,537.72	201,855,418.71
31211	Төрийн сангийн харилцах	92,757,537.72	201,855,418.71
35	БАРАА МАТЕРИАЛ	39,570,675.79	45,773,102.79
354	Хангамжийн материал	39,570,675.79	45,773,102.79
35410	Бичиг хэргийн материал	78,300.00	78,300.00
35420	Аж ахуйн материал	33,646,719.79	40,255,596.79
35440	Түлш шатах тослох материал	838,400.00	838,400.00
35460	Хүнсний материал	5,007,256.00	4,600,806.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	515,451,952.82	718,323,468.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	515,451,952.82	718,323,468.93
392	Биет хөрөнгө	514,407,952.82	717,316,668.93
39201	Барилга, байгууламж	681,820,962.65	959,922,635.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(200,434,746.60)	(265,088,622.36)
39205	Машин, тоног төхөөрөмж	39,709,840.16	30,588,507.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,751,511.81)	(22,653,724.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,989,430.08	58,257,222.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,045,894.30)	(47,149,161.99)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,618,309.21	19,618,309.21
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,417,086.57)	(17,097,147.69)
39217	Номын фонд	918,650.00	918,650.00
393	Биет бус хөрөнгө	1,044,000.00	1,006,800.00
39301	Програм хангамж	160,000.00	160,000.00
39302	Хасагдуулга	(160,000.00)	(160,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,116,000.00	1,116,000.00
39304	Хасагдуулга	(72,000.00)	(109,200.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	647,780,166.33	965,951,990.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	647,780,166.33	965,954,012.43
51	Засгийн газрын хувь оролцоо	647,780,166.33	965,954,012.43
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон	91,984,101.50	171,229,673.50
51101	Өмч: -Төрийн өмч	91,984,101.50	171,229,673.50
512	Хуримтлагдсан үр дүн	221,022,799.27	459,951,073.37
51210	Өмнөх үеийн үр дүн	221,022,799.27	221,022,799.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	238,928,274.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	334,773,265.56	334,773,265.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	647,780,166.33	965,954,012.43

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	489,520,787.18	1,030,684,178.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	(195,300.00)	113,369,466.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	108,969,466.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	108,969,466.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	90,478.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	108,878,988.00
122	Тусламжийн орлого	(195,300.00)	4,400,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	4,400,000.00
122005	Орон нутгийн төсвөөс санхүүжих	(195,300.00)	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	489,716,087.18	917,314,712.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,194,787.18	796,554,912.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,194,787.18	700,596,400.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	95,958,512.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,909,300.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод	5,909,300.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,612,000.00	120,759,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуул	80,612,000.00	120,759,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	415,604,830.97	791,757,925.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,604,830.97	785,642,925.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	409,995,530.97	785,642,925.90
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	256,618,594.52	445,539,296.98
210101	Цалин	214,324,947.91	345,533,618.55
210102	Нэмэгдэл цалин	39,130,637.51	87,695,790.73
210104	Урамшуулал	3,163,009.10	12,309,887.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,857,154.79	57,394,329.89
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,773,146.85	39,229,026.97
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,561,546.65	4,073,346.09
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,049,237.36	3,596,824.24
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	499,984.26	883,057.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,973,239.67	9,612,074.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,425,080.91	93,891,632.14
210301	Гэрэл цахилгааны зардал	6,106,016.91	21,428,894.14
210302	Түлш, халаалтын зардал	42,319,064.00	70,634,538.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	1,828,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	8,768,700.00
210401	Бичиг хэргийн материал	-	4,979,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	-	3,027,700.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	-	762,000.00
2105	Нормативт зардал	10,489,658.00	97,016,996.00
210502	Хоол	10,489,658.00	88,258,396.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	8,758,600.00
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	-	2,150,000.00
210604	Урсгал засвар	-	2,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	927,900.00	1,325,600.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	927,900.00	1,325,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,677,142.75	79,556,370.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,691,000.00	4,326,214.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,986,142.75	75,230,156.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,609,300.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,609,300.00	-
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрө	5,609,300.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	6,115,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	6,115,000.00
221001	Их засвар	-	6,115,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	73,915,956.21	238,926,252.10
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	10.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(10.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	73,915,946.21	238,926,252.10

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	489,520,787.18	821,356,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	(195,300.00)	-
122	Тусламжийн орлого	(195,300.00)	-
122005	Орон нутгийн төсвөөс санхүүжих	(195,300.00)	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	489,716,087.18	821,356,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	403,194,787.18	700,596,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,194,787.18	700,596,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,909,300.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доо	5,909,300.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	80,612,000.00	120,759,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуул	80,612,000.00	120,759,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	391,302,380.22	672,106,779.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,302,380.22	672,106,779.01
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,693,080.22	672,106,779.01
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	256,513,594.52	446,758,096.98
210101	Үндсэн цалин	214,219,947.91	346,752,418.55
210102	Нэмэгдэл	39,130,637.51	86,527,184.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,168,606.06
210104	Үр дүнгийн урамшуулал	3,163,009.10	12,309,887.70
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	32,962,154.79	56,649,128.99
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,878,146.85	38,871,891.74
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,561,546.65	4,518,982.67
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,049,237.36	3,508,322.89
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	499,984.26	883,057.71
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,973,239.67	8,866,873.98
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	48,425,080.91	95,236,233.04
210301	Гэрэл цахилгааны зардал	6,106,016.91	11,947,626.04
210302	Түлш, халаалтын зардал	42,319,064.00	70,634,538.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	12,654,069.00
2105	Нормативт зардал	34,959,200.00	49,977,006.00
210502	Хоол, хүнс	34,959,200.00	49,977,006.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	927,900.00	1,325,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	927,900.00	1,325,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,405,150.00	21,660,714.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,019,700.00	17,264,114.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	4,385,450.00	4,396,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,609,300.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,609,300.00	-
213208	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс ү	5,609,300.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	98,218,406.96	149,249,420.99
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	98,218,406.96	149,249,420.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	92,757,537.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,218,406.96	201,855,418.71

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	344,782,999.90	771,540,366.96
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	344,782,999.90	771,540,366.96
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	221,022,799.27	647,780,166.33
D01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	91,984,101.50	334,773,265.56	221,022,799.27	647,780,166.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,245,572.00	334,773,265.56	221,022,799.27	647,780,166.33
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	79,245,572.00			79,245,572.00
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	171,229,673.50	334,773,265.56	459,949,051.37	965,951,990.43

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	-	92,757,537.72	(92,757,537.72)	
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН	937,836,913.09	699,524,669.01	238,312,244.08	74.6
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	937,836,913.09	699,524,669.01	238,312,244.08	74.6
210	Бараа, үйлчилгээний зардал	937,836,913.09	699,524,669.01	238,312,244.08	74.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,039,800.00	446,758,096.98	93,281,703.02	82.7
210101	Үндсэн цалин	359,879,600.00	346,752,418.55	13,127,181.45	96.4
210102	Нэмэгдэл	169,560,000.00	86,527,184.67	83,032,815.33	51.0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор		1,168,606.06	(1,168,606.06)	
210104	Урамшуулал	10,600,200.00	12,309,887.70	(1,709,687.70)	116.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	66,421,900.00	56,649,128.99	9,772,771.01	85.3
210201	Тэтгэврийн даатгал	45,166,200.00	38,871,891.74	6,294,308.26	86.1
210202	Тэтгэмжийн даатгал	5,313,800.00	4,518,982.67	794,817.33	85.0
210203	ҮОМШӨ ний даатгал	4,251,300.00	3,508,322.89	742,977.11	82.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,063,200.00	883,057.71	180,142.29	83.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,627,400.00	8,866,873.98	1,760,526.02	83.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	194,168,913.09	95,236,233.04	98,932,680.05	49.0
210301	Гэрэл цахилгаан	21,854,913.09	11,947,626.04	9,907,287.05	54.7
210302	Түлш, халаалт	167,753,000.00	70,634,538.00	97,118,462.00	42.1
210303	Цэвэр, бохир ус	4,561,000.00	12,654,069.00	(8,093,069.00)	277.4
2105	Нормативт зардал	106,127,500.00	83,814,046.00	22,313,454.00	79.0
210502	Хоол, хүнс	106,127,500.00	83,814,046.00	22,313,454.00	79.0
2106	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	1,465,500.00	1,325,600.00	139,900.00	90.5
210806	Мэдээллийн технологийн зардал	1,465,500.00	1,325,600.00	139,900.00	90.5
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	28,613,300.00	15,241,564.00	13,371,736.00	53.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,218,700.00	10,844,964.00	13,373,736.00	44.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,394,600.00	4,396,600.00	(2,000.00)	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	845,778,400.00	821,356,200.00	24,422,200.00	97.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	650,631,800.00	700,596,400.00	(49,964,600.00)	107.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	650,631,800.00	700,596,400.00	(49,964,600.00)	107.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС	195,146,600.00	120,759,800.00	74,386,800.00	61.9
132001	Орон нутгийн төсвөөс	195,146,600.00	120,759,800.00	74,386,800.00	61.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний		92,757,537.72	(92,757,537.72)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн		201,855,418.71	(201,855,418.71)	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	23.00	2.00	92.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00		100.0
620003	Үйлчлэх ажилтан	12.00	10.00	2.00	83.3

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 7 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,0 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 23 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтаар 91,0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023. оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71 542.1 сая төгрөгөөр буюу 8,7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	92,757.5	201,855.4	109,097.9
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	39,570.7	45,773.1	6,202.4
Үндсэн хөрөнгө	515,452.0	718,323.5	202,871.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>647,780.2</b>	<b>965,952.0</b>	<b>309,172.0</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	647,780.2	965,954.0	318,174.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>647,780.2</b>	<b>965,954.0</b>	<b>318,174.0</b>

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 109,097.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх оноос орон тоо дутуу ажиллан үндсэн, нэмэгдэл цалин хэмнэснээс шалтгаалан өссөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 6,202.4 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгөөр 108,985.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан мөн хандиваар 6,115.0 мянган төгрөгийн цагаан хэрэглэл, сургалтын хэрэглэгдэхүүн авсан цэцэрлэгийн өөрийн үйл ажиллагаанд 108,898.4 мянган төгрөгийн хангамжийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 202,871.5 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барилгын өргөтгөл шинэчлэлийг 273,701.7 мянган төгрөгөөр, хандиваар цэцэрлэгийн 1-р цахилгааны дотор монтажны ажлыг 4.400.0 мянган төгрөгөөр тус тус хийсэн.

Борнуур сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны 09 дүгээр тогтоолоор Хүүхдийн цэцэрлэгийн 162 нэр төрлийн нийт 19,853,5 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, акталсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 650,631.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 195,146.6 мянган төгрөг нийт зарлагыг 845,778.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 845,778.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 845,778.4 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 821,356.2 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 700,596.4 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 120,759.8 мянган төгрөг нийт 821,356.2 мянган төгрөгийг санхүүжилтээр авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 699,524.7 мянган төгрөг буюу 74.6% хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 238,312.2 мянган төгрөгөөр хэмнэсэн, үүнээс цалин хөлстэй холбоотой зардлыг 103,054.5 мянган төгрөгөөр, байр ашиглах зардал, хоол хүнсний зардлыг 155,279.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвөөс 120,759.8 мянган төгрөгөөр тогтмол зардлыг санхүүжүүлсэн.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,198.3	1,345.0	1,043.3	100%
2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	103,139.3	84,745.5	18,407.5	82.1%
3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	5,582.6	5,500.0	82.6	98.5%
4	81823-Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	2,198.3	1,636.0	562.3	74.4%
5	81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	21,330.1	21,330.1		100%
6	81834 Боловсролын стандарт	382,958.5	382,958.5		100%
7	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	133,221.0	133,221.0		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	100%	2,198.3	1,345.0
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	82.1%	103,139.3	84,745.5
3	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	98.5%	5,582.6	5,500.0
4	71801-81823	2023-12-31	Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	74.4%	2,198.3	1,636.0
5	71801-81832	2023-12-31	Нүүдлийн бүлэгт хамруулах	100%	21,330.1	21,330.1
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	100%	382,958.5	382,958.5
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	100%	133,221.0	133,221.0

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, ЕБС цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Борнуур сумын хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Төв аймгийн Боловсролын газраас тендерт шалгаруулсан газруудаас шууд худалдан авалт хийсэн. Үүнд: Эрхэм Ундраа ХХК-аас хүнс 23.9 мянган төгрөгийн хүнсний материал, Галтбадрах ХХК-аас хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх махан бүтээгдэхүүнийг тус тус худалдан авалт хийсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар, нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 02 дүгээр сарын 14-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Борнуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 425,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 8,500.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,800.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 93,282.0 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 98,933.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 158 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 1 мэдээлэл хоцроож байршуулсан байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулав.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Борнуур сумын хүүхдийн цэцэрлэг нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	6	8,027.1	6	8,027.1	100
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	6	8,027.1	6	8,027.1	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,318.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 21,318.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: 2023 оны эхний 3 улирлын байдлаар 21,318.0 мянган төгрөгөөр төсвийн гүйцэтгэл хэтэрсэн байсан. 2023 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар цалин нэмэгдэл, урамшууллыг 93,281.7 мянган төгрөгөөр хэмнэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт журам заавар, энэ хуулийн 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн” Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна “гэснийг үндэслэн зардлуудыг хянахад гүйцэтгэлийн үе шатанд дээрх зардлууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон төсвийн гүйцэтгэлийн тайлангаар цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 93,281.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаар тайлагнасан байна.

### 1 Төлбөрийн акт.

1. Зардлын данстай холбоотой

#### Илрүүлэлт

2023 оны 1-р сард хүүхдийн хоолны орц нормыг хэрэгжүүлэн ажиллаагүйн улмаас 197.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А166, А1556, 222 тоот хамтарсан тушаалын заалт, Төсвийн тухай хуулийн 6.4.1 Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-т заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөв зарцуулалттай холбоотой	1	21,318.0					1	21,318.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>21,318.0</b>					<b>1</b>	<b>21,318.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2023 оны 1-р сард хүүхдийн хоолны орц нормыг хэрэгжүүлэн ажиллаагүй	1	197.6	1	197.6								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>197.6</b>	<b>1</b>	<b>197.6</b>								

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)